



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ХҮҮХДИЙН  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2026 оны 06 сарын 18 өдөр

Дугаар Б/22

Цэнхэрмандал сум


Мөнгөн урамшуулал олгох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2022 оны 10 сарын 26-ны өдрийн А/430 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Багшийн ажлын үнэлгээний үр дүнгээр 97.06 %-тай, индексийн түвшин III-д үнэлэгдсэн багш Б.Нандин-Эрдэнэд 2026 оны 4, 5, 6-р сарын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн мөнгөн урамшууллыг бодож олгосугай.

2. Мөнгөн урамшууллыг тухайн кластер дахь багшийн эрэмбийн хувь  $75 < M < 85$  харгалзуулан албан тушаалын үндсэн цалинг сар бүр 20 хувиар тооцож 6 дугаар сард олгохыг нягтлан бодогч Д.Ганчимэгт зөвшөөрсүгэй.

ЭРХЛЭГЧ



П.ГАНТУЯА